



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 05 сарын 23 өдөр

Дугаар А/14

Бат-Өлзий сум

Засаг даргын Тамгын газрын дотоод  
журам шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 122 дугаар зүйлийн 122.1, 122.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Засаг даргын Тамгын газрын шинэчилсэн дотоод журмыг хавсралтаар баталсугай.

2. Дотоод журмыг батлагдсан өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг нийт албан хаагчдад үүрэг болгосугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан “Засаг даргын Тамгын газрын даргын дотоод журам шинэчлэн батлах тухай” 2020 оны 10 дугаар сарын 20-ний өдрийн А/19 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Н.БАТ-ЭРДЭНЭ